

ШУТИС-ИЙН 2022 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Хамтын гэрээний зорилго нь: ШУТИС-ийн профессор багш, ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, Хөдөлмөрийн тухай хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхэд оршино.

1.2 Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, хуульчилсан актуудыг үндэслэн ажил олгогчийг төлөөлж ШУТИС-ийн **Захиргаа**, хамт олныг төлөөлж **Үйлдвэрчний эвлэлийн хороо (ҮЭХ)** /цаашид талууд гэх/ харилцан тохиролцож энэхүү хамтын гэрээг байгуулав.

1.3 Хамтын гэрээ нь ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, талуудын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх харилцааг зохицуулна.

1.4 Хамтын гэрээ байгуулагч талуудын харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

1.5 Энэхүү гэрээ нь байгуулсан өдрөөс эхлэн дараагийн Хамтын гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

1.6 Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талууд бие биедээ бичгээр хүсэлт гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор асуудлыг авч хэлэлцэнэ.

1.7 Хамтын гэрээний хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг Талууд хамтран боловсруулж хэрэгжүүлнэ. Ажлын төлөвлөгөөг гэрээний хавсралтаар батлах бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

1.8 ШУТИС-д дагаж мөрдөх дүрэм журмын хэрэгжилтэд гэрээнд оролцогч талууд хяналт тавьж ажиллана.

Хоёр. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нэмэгдлийн талаар

2.1 ШУТИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд нь профессор багш, ажилтантай Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулах бөгөөд жил бүр дүгнэж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.

2.2 МУ-ын Үндсэн хуулийн дагуу профессор, багш нарын цагийн сургалтын хичээллэх цаг, цагийн тооцоог ШУТИС-д мөрдөж буй журмаар бүрэн тооцож, хөлсийг нь олгоно.

2.3 БСШУСЯ-ны “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын дагуу ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил, 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулна.

2.4 ШУТИС-ийн профессор, багш, ажилтны үндсэн цалинг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 10%-иар нэмэгдүүлнэ. 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс профессор багш нарын цалинг 10%-иар, ажилтны цалинг 5%-иар тус тус нэмэгдүүлнэ.



2.5 Профессор, багш нарын заавал биелүүлэх ноогдлоос давсан илүү кредит цагийн нэг кредитийн үнэлгээг 400000 төгрөгөөр 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцно.

2.6 “ШУТИС-ийн багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журам”-ын үйлчлэлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс түр зогсоож, урамшуулалд олгож байсан мөнгийг тухайн өдрөөс эхлэн багш, ажилтны албан тушаалын үндсэн цалингийн 10%-иар бодож сар бүр олгоно.

2.7 Профессор, багш нар хүрэлцээгүй, зайлшгүй тохиолдолд илүүгийн илүү цагийн хөлсийг холбогдох журамд зааснаар тухайн хичээлийн жилд бодож олгоно.

2.8 ШУТИС-ийн профессор, багш, ажилтны цалин хөлсийг сард 2 удаа олгоно. Хэрэв энэ өдөр нь нийтээр амрах баярын өдөртэй давхцавал урьд өдөр нь олгоно.

2.9 Нийтээр амрах баярын өдөр тасарсан хичээлийг профессор, багш нар агуулгаар нь нөхөх үүрэгтэй бөгөөд ийнхүү тасарсан хичээлийг багшийн гүйцэтгэлээс хасахгүй.



2.10 Үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ажилтанд хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож нэмэгдэл хөлс олгоно.

2.11 Биеийн тамирын багш, ажилтнуудын спортын мастерын нэмэгдлийг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд зохих журмын дагуу бодож олгохыг тэдний хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнэ.

2.12 Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг захиргаа аж ахуйн ажилтан тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын дагуу олгоно.

2.13 ШУТИС-ийн профессор, багш, ажилтан өөрийн цалингийн хэмжээ болон бусад нэмэгдлийн талаар мэдээлэл авах эрхтэй. Бүрэлдэхүүн сургуулийн санхүүгийн ажилтан болон хүний нөөцийн ажилтан тухай бүрд нь мэдээлэл өгөх үүргийг хүлээнэ.

Гурав. Ажил амралтын цаг

3.1 Ажлын цагаар мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан профессор багш, ажилтны ажлын цагийг суралцаж байх хугацаанд нь ажил олгогч богиносгож, үндсэн цалин, урамшууллыг бүрэн олгоно.

3.2 Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагын цагийг хуульд зааснаар олгох бөгөөд энэхүү цагийг ажлын цагт оруулан тооцно.

3.3 ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтан Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон ХНХ-ын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 тоот тушаалаар баталсан журмын дагуу ээлжийн амралтаа биеэр эдэлж, ээлжийн амралтын олговроо бүрэн авна. Ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй профессор, багш нарын амралтын үлдсэн хоногийг заавал биеэр эдлүүлнэ.

3.4 Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтныг тухайн жилд нь багтааж амруулах, нөхөн амруулах боломжгүй бол мөнгөн урамшуулал олгоно. Ажилласан нэг өдрийн мөнгөн урамшууллын хэмжээ нь тухайн албан тушаалтны үндсэн цалингийн нэг өдрийн хөлстэй тэнцүү байна.

3.5 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэн ажиллуулах, шилжүүлэх боломжгүй бол ажилтанд үндсэн цалингийн 75 хувиар олговор олгоно.

3.6 Шөнийн цагаар болон амралтын өдрүүдэд ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно.

3.7 Ажил олгогч профессор багш, ажилтанд цалинтай чөлөө олгох асуудлыг Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

3.8 ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн багшийн долоо хоногийн ажлын цаг 40 цаг байна.

3.9 БСШУСЯ-ны “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын дагуу ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн сургалтын төлөвлөгөөний 1 цаг буюу хичээл заасан 45 минутыг ажлын нэг цагаар тооцно.

НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Дөрөв. Нийгмийн асуудлын талаар

4.1 ШУТИС-ийн багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үлгэрчилсэн журамд заасны дагуу бүрэлдэхүүн сургуулиуд орлогынхоо 2 хувийг багшийг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу зарцуулах бөгөөд бүрэлдэхүүн сургуулиудын чанарын албаны менежер, ҮЭ-ийн хороо хяналт тавина.

4.2 Хөдөлмөрийн хуулийн дагуу тэтгэвэрт гарах эрх нь үүссэн профессор, багш, ажилтан ШУТИС-д тасралтгүй ажилласан (Гадаадад магистр, докторт суралцсан, хувиараа чөлөө авсан хугацааг тооцохгүй) тохиолдолд тэтгэвэрт гарахад нь дараах сарын үндсэн цалингийн хэмжээтэй тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг олгоно. Үүнд:

	ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмж авах сарын тоо		ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмж авах сарын тоо
	121-156 сар	3 сарын цалин		241-252	11 сарын цалин
	157-168	4 сарын цалин	0	253-264	12 сарын цалин
	169-180	5 сарын цалин	1	265-276	13 сарын цалин
	181-192	6 сарын цалин	2	277-288	14 сарын цалин
	193-204	7 сарын цалин	3	289-300	15 сарын цалин
	205-216	8 сарын цалин	4	301-312	16 сарын цалин
	217-228	9 сарын цалин	5	313-324	17 сарын цалин
	229-240	10 сарын цалин	6	325 сараас дээш	18 сарын цалин

4.3 МУ-ын Засгийн газрын 2010 оны 01-р сарын 20-ны өдрийн 15-р тогтоолоор ШУТИС-д бусад сургуулиас шилжин ирсэн багш нарт тэтгэвэрт гарахад нь тэтгэмжийг олгохдоо боловсролын байгууллагад 15-18 жил хүртэл ажилласан профессор багш тэтгэвэрт гарахад 3 сарын; 18-21 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад 6 сарын; 21-25 жил хүртэл ажилласан багш 9 сарын; 25 ба түүнээс дээш жил ажилласан багш тэтгэвэрт гарахад 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж тус тус олгоно.

4.4 ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд ЕБС-иас ирсэн Хөдөлмөрийн хуулийн дагуу тэтгэвэрт гарах эрх нь үүссэн, боловсролын байгууллагад 15-18 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад нь 3 сарын, 18-21 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад нь 6 сарын, 21-25 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад нь 9 сарын, 25 ба түүнээс жил ажилласан багш тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмж тус тус олгоно.


4.5 ШУТИС-иас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсгэлгүй “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзлыг хангаж өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр өмнө нь тогтоолгосон ШУТИС-ийн профессор, багш, ажилтан нарт хамтын гэрээнд заагдсан нэг удаагийн тэтгэмж олгогдохгүй.

4.6 Тус сургуульд ажиллаж байгаа профессор багш, ажилтан нас барвал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх, тус сургуулиас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан нас барвал 400000 төгрөгийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.

4.7 Профессор багш, ажилтны төрсөн эцэг эх, ах эгч дүү, нөхөр эхнэр, хүүхэд нь нас барвал 300000 төгрөгийн тусламж үзүүлнэ.

4.8 Өөрийн оршин суудаг гэр орон нь гал түймэр, үер усны гэх мэт давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд профессор, багш, ажилтанд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгоно.

4.9 Төрийн байгууллагад 20-иос доошгүй жил, үүнээс ШУТИС-д 10-аас доошгүй жил ажилласан профессор, багш, ажилтанд ээлжийн амралтаараа магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилал, эмчилгээнд явах тохиолдолд 300000 хүртэл төгрөгийн буцалтгүй тэтгэмжийг холбогдох баримт үндэслэн 3 жилд нэг удаа олгох асуудлыг ШУТИС-ийн захиргааны ажилтанд захиргааны зөвлөлийн, бүрэлдэхүүн сургуулиудад сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар тус тус шийдвэрлэнэ.



4.10 Сургууль, салбар нэгжийн хамт олны өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулахад зориулан Горхи дахь полигонд очих, ирэхээр тооцож, унааны зардал болон холбогдох бусад зардлыг жилд 1 удаа тухайн сургууль, нэгж хариуцан гаргана.

4.11 Ахмад настнуудыг цагаан сар, ахмадын баярын өдрийг тохиолдуулан жилд 2-оош доошгүй удаа хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ.

4.12 ШУТИС-д ажиллаж байгаа профессор багш, ажилтан эрэгтэй 60, эмэгтэй 55 нас хүрэхэд нэг удаа 300000 төгрөгийн зардал гаргаж, хүндэтгэл үзүүлнэ.

4.13 Тус сургуульд 5-аас дээш жил хариуцсан ажилдаа идэвх зүтгэлтэй ажилласан ажилтан бакалавр ба магистрын түвшинд суралцах эрхийн шаардлага хангасан хүний ШУТИС-д суралцахаар сонгосон мэргэжлээр нь суралцах хугацаанд нь нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50%-иар нэг удаа хөнгөлж суралцуулна.

4.14 ШУТИС-ийн багш, ажилтан докторын зэргийн урьдчилсан хамгаалалтыг амжилттай хамгаалсан бол 1500000 төгрөгний тэтгэмжийг нэг удаа олгоно.

4.15 Багш нарын баярын өдрийг тохиолдуулан “ШУТИС-ийн профессор, багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам” болон “Оны шилдэг багш шалгаруулах журам”-д заасны дагуу шилдэг профессор, багш нарыг шалгаруулан шагнаж урамшуулна. Урамшууллыг ШУТИС-ийн төсөвт тусгасан зардлаас гаргана.

4.16 Нийт профессор, багш, ажилтныг орон сууцаар хангах зорилгоор арилжааны банкнууд, орон сууцны корпорац, аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулж, орон сууц авах багш, ажилтныг хөнгөлөлттэй /5-8% хүүтэй/ урт хугацааны зээлд хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

4.17 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Ном сурах бичгийн зөвлөл ба салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр зөвшөөрөгдсөн сурах бичиг, сургалтын гарын авлагыг хэвлүүлэх, олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх эрх авсан хүнд хэвлэлтэй холбоотой зардлыг бүрэлдэхүүн сургуулийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

4.18 ШУТИС-д 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа багш, ажилтан хүнд өвчин (эмнэлзүйн, лабораторийн аргаар мэргэжлийн байгууллагаар тодорхойлсон дүгнэлт)-ийн улмаас эх орондоо болон гадаад улсад 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй эмчилгээ хийлгэх тохиолдолд ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэрээр харъяалах нэгж нь 2 сая төгрөг, бусад бүрэлдэхүүн сургууль, захиргаа тус бүрээс 200000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл

5.1 Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-г заасны дагуу сургууль тус бүр төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зардлын 0.5%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна. ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл төлөвлөгөө гаргаж хариуцан ажиллана. Зарцуулалтыг жилд 2 удаа тайлагнана.


5.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөлд талууд ижил тэгш эрхтэй оролцоно. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл нь хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, ажлын байр хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах ажлыг төлөвлөгөө гаргаж, зохион байгуулна.

5.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангах, хөдөлмөр хамгааллыг сайжруулах арга хэмжээний хөтөлбөрийг ҮЭХ-той зөвшилцөн баталж мөрдүүлнэ.

5.4 Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.1, 80.1.2-г заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд тус хуулийн 82.1-р зүйлд заасан хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

5.5 ШУТИС-ийн Захиргаа нь ҮЭНХ-той зөвшилцөн Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг шинэчлэн эрчимжүүлж ажиллуулна.

5.6 Мэргэжлийн онцлогоос хамааруулан ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шаардлагатай хөрөнгийг 5.1-т заасан сангаас гаргана. Зохих арга хэмжээг



сургуулийн захиргаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан орон тооны бус зөвлөл авна.

5.7 Хөдөлмөр хамгаалах хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн Стандарт Хэмжил зүйн Газраас тогтоосон норм, журмын дагуу хүрэлцэхүйц хэмжээгээр захиалж, хугацаанд нь олгоно.

5.8 Хүнд, хортой нөхцөлд ажилладаг багш, ажилчин, сургалтын мастер, архивын ажилтан /үүнд архив хариуцан ажиллаж буй албан тушаалтан хамаарна/, номын санч, бохирын слесарь, ариун цэврийн өрөөний үйлчлэгч нарт ажлын өдөр бүрээр үнийн дүнг 1800 төгрөгөөр тооцож хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн болох 0.5 литр сүүг олгоно. Эдгээр албан тушаал дээр ажиллаж буй хүмүүс болон бүх үйлчилгээний ажилчдад харшлын сорил тавиулах ажлыг сургуулийн захиргаанаас жилд нэг удаа зохион байгуулж, гарах зардлыг 5.1-д заасан сангаас гаргана.

5.9 Ажилчдад олгох ажлын хувцас, багаж хэрэгсэл, үйлчилгээний ажилчдад олгох цэвэрлэгээний материалын чанарыг сайжруулж, хүний биед хоргүй угаалгын бодисыг зохих нормын дагуу сургуулиуд нь хариуцан олгоно. Эдгээр зүйлүүд чанарын шаардлага хангаж буй эсэхийг ХАБЭА хариуцсан орон тооны бус зөвлөлөөс улиралд нэг удаа шалган дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг засах арга хэмжээ авна.

5.10 Тоостой /тоосонцортой/ нөхцөлд ажилладаг номын сангийн ажилтан, архивын ажилтан, сургалтын албаны ажилтны ажлын байрны нөхцөлийг сайжруулж, агаар чийгшүүлэгч суурилуулж, арчих, цэвэрлэгээний материал олгоно.

5.11 ШУТИС-ийн хичээлийн байруудыг жилд 2 удаа ариутгаж, халдваргүйжүүлэлт, мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Үүнтэй холбогдох зардлыг гэрээний 5.1 дэх заалтын дагуу бүрдүүлэх хөрөнгөөс гаргана.

5.12 Профессор, багш, ажилтны ажлын өрөөний галын аюулгүй байдлыг хангана. Подвалд байрлаж байгаа профессор, багш, ажилтны өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт зэргийг эрс сайжруулж, стандарт хэмжээнд хүргэх арга хэмжээг авна.

5.13 ШУТИС-ийн хичээлийн байрнуудын ариун цэврийн өрөөнүүдийн тохижилтыг эрс сайжруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гар угаах шингэн саван, ариутгагч уусмал, гар хатаагч, багш нарын өрөө болон коридорт ус цэвэршүүлэгч зэргийг байрлуулах талаар арга хэмжээ авна.

5.14 ШУТИС-ийн цайны газруудын тохижилт, хоолны чанар, ариун цэврийг дээшлүүлнэ.

5.15 МУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйлийг үндэслэн ШУТИС-ийн нийт профессор, багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулна. Эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцах бөгөөд 1 хүнд 40000 төгрөгөөр бодож сургуулийн зүгээс санхүүжүүлнэ.

Зургаа. Талуудын хамтын ажиллагаа

6.1 Мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ажил олгогч ҮЭ-тэй хамтран бүрэлдэхүүн сургуулиудын удирдах албан тушаалтан, профессор, багш, ажилтанд зориулан жилд 1-ээс доошгүй удаа төрөл бүрийн сургалт зохион байгуулна.


6.2 Үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультанд тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулан сахилгын шийтгэл ногдуулах, хэлэлцээрт оролцсоных нь төлөө өөр ажилд шилжүүлэх, ажил олгогчийн санаачлагчаар хэлэлцээний туршид болон хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор ажлаас халахыг хориглоно.

6.3 ШУТИС-ийн хамтын удирдлагын байгууллагуудад Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөллийг оруулна.

6.4 ҮЭ-ийн гишүүдийн татварыг цаг тухайд нь салбар хороодын данс руу бэлэн бусаар хурааж шилжүүлэх үүргийг бүрэлдэхүүн сургууль, бусад нэгжүүд хүлээнэ.

6.5 ҮЭ-ийн төлөөлөгчид дараах комисс, зөвлөлийн үйл ажиллагаанд заавал оролцоно. Үүнд:

- Хамтын гэрээний хэрэгжилтийг хянах комисс,
- Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс,
- Үйлдвэрийн ослын шалтгаан тогтоох комисс,
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл.



Долоо. Гэрээний биелэлтийг хянах, мэдээлэх

7.1 Захиргааны зүгээс профессор багш, ажилтны санал хүсэлтийг жилд нэг удаа нэгдсэн журмаар сонгож Хамтын гэрээний биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлнэ.

7.2 Хоёр тал гэрээний хэрэгжилттэй холбоотой өөрт байгаа бүх мэдээллийг нээлттэй солилцоно.

7.3 Хамтын гэрээний хэрэгжилтэд талууд хяналт тавина.

7.4 Хамтын гэрээг биелүүлэх явцад үүссэн саналын зөрүүтэй асуудлыг “Хөдөлмөрийн тухай” хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ажил олгогчийг төлөөлж:

ШУТИС-ийн ХБЦО дэд захирал
..... Д.Мягмарсүрэн

ШУТИС-ийн ЭШИГ-ын дарга
..... Т.Энхцацрал

ГХС-ийн захирал
..... Ц.Энхбаатар

ХШУС-ийн захирал
..... В.Өлзийбаяр

ЭХС-ийн захирал
..... Б.Бат-Эрдэнэ

Ажилтныг төлөөлж:


ШУТИС-ийн дэргэдэх ҮЭХ-ны дарга
..... С.Дэлгэрмаа

БухС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... А.Болормаа

ХШУС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... Д.Хандмаа

МехТС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... Ж.Давааням

ЗАА-н ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... Ц.Сэрчмаа



2022 оны хичээлийн жилийн Хамтын гэрээний ажлын төлөвлөгөө

№	Гүйцэтгэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
1	ШУТИС-ийн дотоод үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг санхүүгийн жилээр төлөвлөх	2022.01 сар	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар	
2	ШУТИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг батлуулж, ажлын байрны тодорхойлолт шинэчлэн боловсруулж, баталж мөрдөх	2022.01 сар	Захирал, Захиргаа, хүний нөөцийн газар, ҮЭХ	
3	Хөдөлмөрийн маргаан таслах комиссыг ажиллуулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа, ҮЭХ	
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдал, осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан сан байгуулж, зарцуулалтын төлөвлөгөө гаргаж, баталж, мөрдүүлэх	Жилийн турш	Санхүү, хөрөнгө оруулалтын газар, бүрэлдэхүүн сургуулиудын захирлууд, ҮЭСХороод	
5	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлэн ажиллуулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа	
6	Ажилчдад олгох ажлын хувцас, багаж хэрэгсэл, үйлчилгээний ажилчдад олгох цэвэрлэгээний материал чанарын шаардлага хангаж буй эсэхийг шалган дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг засах арга хэмжээ авч ажиллах	Улиралд нэг удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл	
7	“ШУТИС-ийн багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үлгэрчилсэн журам”-ын дагуу бүрэлдэхүүн сургууль бүр хөрөнгө төвлөрүүлж, зарцуулах ажлын төлөвлөгөө гаргах	2022.01 сар	Бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, ҮЭСХороод	
8	Багш, ажиллагсдад орон сууц авахад нь дэмжлэг үзүүлэх, арилжааны банк, орон сууцны корпорац, аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулах, зээлд хамруулах ажлыг эрчимжүүлж ажиллах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа	
9	Хичээлийн байруудын ариутгал, халдваргүйжүүлэлт, мэрэгч, амьтан устгах ажлыг зохион байгуулах	Жилд 2 удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, байрны зохион байгуулагч нар	
10	Цайны газруудын ариун цэвэр, хоолны чанарт хяналт тавих	Жилийн турш	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл	
11	Хичээлийн байрнуудын ариун цэврийн өрөөний тохижилтыг хариуцаж хийлгэх. Багш нарын өрөө, коридорт ус цэвэршүүлэгч байршуулах ажлыг хийлгэх.	Жилийн турш	Байр ашиглалтын захиргаа, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, байрны зохион байгуулагч	
12	Багш нарын өрөөний галын аюулгүй байдлыг хангах, агааржуулалт, гэрэлтүүлэг зэргийг стандартын шаардлагын дагуу суурилуулж, ажиллуулах	Жилийн турш	СЭЗГазар, бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл	
13	ШУТИС-ийн нийт профессор, багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газар	